

1	2	3	4	5	6	7
ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
Зорилго таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.	9.Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.	20212 030	-	Үзэл баримтлал батлагдсан	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалд 2040 он хүртэл тогтвортой, идэвхтэй, дасан зохицох, цогц цомхон, хүртээмжтэй, ухаалаг, хэмнэлттэй хот гэсэн 6 үндсэн зорилгыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан батлуулах ажил хийгдэж байгаа бөгөөд Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 33 дугаар хуралдааны шийдвэр, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоол болон Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, Нийслэл Улаанбаатар хотын 14 хот 3 дагуул хот болгон хөгжүүлэх шийдвэр гарсныг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1189 дүгээр захирамжийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Монгол Улсын сайд, 20 минутын үндэсний хорооны дарга болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын хамтран баталсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар”-ын дагуу “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, тус газраас захиалагчийн хяналтыг тавин ажиллаж байна.	90
Хүн төвтэй хот						
Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи	Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2023 оны А/93 дугаар тушаалаар “Экологийн коридорыг тусгай хэрэгцээнд авах тухай” ажлын хэсэг байгуулагдсаны дагуу тус газраас ажлын хэсэгт ажиллаж, холбогдох саналуудыг тусган,	20212 030	-	Үзэл баримтлал батлагдсан	“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2023 оны А/93 дугаар тушаалаар “Экологийн коридорыг тусгай хэрэгцээнд авах тухай” ажлын хэсэг байгуулагдсаны дагуу тус газраас ажлын хэсэгт ажиллаж, холбогдох саналуудыг тусган,	100

1	2	3	4	5	6	7
бүхий амьдралын таатай орчинтой хот болно.					Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/18 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд 14419га, Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороонд 5928га талбай бүхий экологийн хамгаалалтын бүсэд хамаарах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, хил заагийг тогтоосон.	
Хүрэх үр дүн: 9.Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.				-	“Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1044 дүгээр “Хотын стандартын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, иргэд, олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, хянан тохиолдуулах эрх бүхий байгууллагаар батлуулах асуудлыг хариуцан зохион байгуулах” ажлын хэсэг танилцуулан 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр олон нийтээр хэлэлцүүлж, ажлын хэсгийн хоёрдугаар хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 12 дугаар сард багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	90
2.	9.1.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт орчны стандарт мөрдүүлнэ.	2021 2030	-	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчны стандартыг боловсруулсан	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит бус V хурлын 19 дүгээр тогтоолоор дараах хотын стандартууд батлагдсан бөгөөд Нийслэлийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд: ✓ “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага”; ✓ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага”. Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд: 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, БЕГ, Нийслэлийн Боловсролын газартай хүүхэд багачуудын суралцах аюулгүй орчныг хангуулах чиглэлээр хамтран ажиллах уулзалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын засвар,	100

1	2	3	4	5	6	7
					тохижилтын ажлын даалгаварт батлагдсан хотын стандартыг тусгах талаар санал солилцов. Нийслэлийн Боловсролын газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хотын стандартын тогтолцоо болон сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулж, 40 албан хаагч хамрагдав.	
3.	9.2.13. Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.	2021 2030		Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 47 хэсэгчилсэн талбарт барилгажилтын төсөл баталсан.	- Гэр хорооллын нутаг дэвсгэрт дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хот байгуулалтын БНБД, стандарт мөрдүүлж, зөвлөмж, арга зүйгээр ханган зураг төсөл зохиогч аж ахуй нэгжийн 10 барилгажилтын төсөл, 8 байршилд загвар зургийг хянан баталсан. - Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 5 байршилд мэдээлэл холбооны худаг сувагчлалын төлөвлөлтийн шийдэл, 4 байршилд дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, 5 байршилд гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг тус тус зөвшилцсөн. - Баянзүрх дүүргийн 13,14 дүгээр хороо гэр хороолол дахин төлөвлөлтийн төслийн "Г" хэсэгчилсэн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн МЗХ2024/00-134 дугаартайгаар батлуулсан. - Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 3 байршилд гудамж замын сүлжээний төлөвлөлтийн шийдэл хянаж, санал зөвлөмж өгсөн. - Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллыг дахин орон сууцжуулах төсөл Чингэлтэй дүүрэг, 14,16,18 дугаар хороо, Баянхошуу дэд төв орчмын дахин төлөвлөлт Сонгинохайрхан дүүрэг 8 дугаар хорооны 15 га нэгж талбарт төлөвлөгдсөн барилгажилтын төсөл, Баянхошуу дэд төв орчмын дахин төлөвлөлт Сонгинохайрхан дүүргийн 8,9 дүгээр хорооны 20 га талбайд төлөвлөгдсөн барилгажилтын төсөл, Багануур дүүргийн 2 дугаар хороонд байрлах Шинэ	100

1	2	3	4	5	6	7
					суурьшлын Б төслийн зам, замын байгууламжийн төлөвлөлтийн шийдлийг тус тус зөвшилцсөн.	
4.	9.2.23. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин цэвэршүүлнэ.	2021 2030	350 сая ам доллар	Ажлын зургийн даалгавар боловсруулагдсан . Ажлын зураг төсөл зөвшилцсөн.	Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах төсөл хөтөлбөрийн 1-р хэсгийн хүрээнд Био комбинатаас цэвэршүүлэх үйлдвэр, Шувуун фабрикаас цэвэршүүлэх үйлдвэр, цэвэршүүлэх үйлдвэрээс Баянголын аманд байрлах төвийн цэвэр усны ф600 мм-ийн шугамд холбогдох ажлын зургийн зөвшилцсөн трассыг Хот байгуулалтын мэдээллийн сан "eবাটা" цахим системд оруулсан. Төслийн хүрээнд ус дахин цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 82,4%-ийн гүйцэтгэлтэй байна.	100
5.	9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.	2021 2030	НИТХ-ын Дарга 2024 онд 150.0 (сая)	780 барилга	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/28 дугаар захирамжаар газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажилд 150.000.000 төгрөг батлагдаж эрх шилжиж ирсэн. Тус захирамжийн хүрээнд 2024 оны 03 сарын 22-ны өдөр "Орон сууц болон олон нийтийн зориулалттай 18 барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын даалгавар", 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Үнэлгээний хороог байгуулан Газрын даргаар батлуулсан болно. Орон сууц, олон нийтийн зориулалт бүхий 18 барилгад худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, 2024 оны 05 сарын 20-ны өдрүүдэд тус тус олон нийтэд нээлттэй тендерийг зарласан боловч тендер шалгараагүй. Иймд 2024 оны 06 сарын 24-ний өдөр дахин тендер зарлан "Интеллект тауэр" ХХК шалгарсан. "Интеллект тауэр" ХХК-тай 2024 оны 08 сарын 07-ны өдөр НХБХГ/20230403001/04/01 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан захиалагчийн хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 09 сарын 10-ны өдөр эхлэлийн тайлан, 2024 оны 10 сарын 30-ны өдөр эцсийн тайланг албан бичгээр ирүүлсэн. Тайлангаар 18 барилгад	100

1	2	3	4	5	6	7
					Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: ✓ Орон сууцны зориулалт бүхий 5, ✓ Олон нийтийн зориулалт бүхий 5, ✓ Гал унтраах ангийн 3, инженерийн дэд бүтцийн 5 барилга	
6.	9.2.34. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулан батлуулж, эрсдэлтэй бүсүүдэд гидрогеологийн хэмжилт хийж, цооног байгуулж хяналтын нэгдсэн системд холбоно.	2021-2030	1.2 тэрбум төг	Ажлын зургийн даалгавар батлагдсан.	Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламжийн төлөвлөлтийн шийдлийг 52 байршилд боловсруулан Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 13 удаагийн хурлаар хэлэлцүүлж ажлын зургийн даалгавар боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	100
7.	9.2.35. Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн мэдээлэл, харилцаа холбооны тогтолцоо, нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох, инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн	2021 2030	-	Инженерийн бэлтгэл арга хэмжээний шугам 5807 м ажлын зураг төсөл зөвшилцсөн.	Инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын хүрээнд 2024 онд 62 ажлын зураг төсөл зөвшилцөж хот байгуулалтын мэдээллийн сан “ebariga” цахим системд оруулж, хамгаалалтын зурвас тогтоосон.	100

1	2	3	4	5	6	7
	хангасан үерийн эрсдэлгүй хот болно.					
Санал дүгнэлт: -						
Зорилт 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.	2021-2030	-	УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо- 1	“Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын гэрээ 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/A/893/01 дугаартай батлагдаж, дундын тайланг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 39 дүгээр хурлаар хэлэлцүүлж, зөвлөлийн гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тусган ажлын гүйцэтгэлийг сайжруулан дахин хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/580 дугаартай гэрээний хугацаа сунгах албан бичиг ирүүлсэн тул 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 2023/A/893/02 дугаартай хугацаа сунгах нэмэлт гэрээгээр ажлын хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан. Улмаар Хот төлөвлөлт судалгааны институтээс 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр дундын тайланг ирүүлсэн бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 9 дүгээр хэлэлцүүлж дэмжигдэн, хурлын гишүүдийн санал дүгнэлтийн дагуу сайжруулан гүйцэтгэлийг хүлээн авсан. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-ний Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, ажлын даалгаврыг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлуулсан. 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн НХААГ/20240103147 тоот гэрээг “Дэхан консалтентс” ХХК-тай байгуулж, гэрээний дагуу Захиалагчийн хяналт тавин эцсийн тайланг хүлээн авсан. Зөвлөх үйлчилгээний үе шатны тайлангуудыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах төслийн нэгж, Авто замын газар, Нийслэлийн Орон сууцны корпораци, Хот төлөвлөлт судалгааны институтаар хэлэлцүүлсэн. Тайлант хугацаанд нийт 14 бүлэг саналыг ирүүлж, эцсийн тайланд		
						100

1	2	3	4	5	6	7
					тусгаж ажилласан. Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 2024/08 дугаартай албан бичгээр ирүүлж, нийслэлийн Ерөнхий архитектурын дэргэдэх Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 22 дугаар хурлаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. Улаанбаатар хотын Дагуул, хаяа, хот тосгодын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж буй байршлуудаас эхний ээлжид Буянт-Ухаа, Налуу-Ухаа, Аргалант эмээлт дагуул хот байгуулах эдэлбэр газар, хэмжээ, байршлыг судалж, Дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах суурь судалгааг боловсруулсан. Улмаар судалгаанд үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га талбайд хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр, Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5,650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр тус тус эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай санал боловсруулж, Засгийн газрын тогтоолын төсөл, төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж, яамдаас санал авч, ирүүлсэн саналыг тусган Улсын их хуралд өргөн мэдүүлж, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Эдийн засгийн тусгай бүс байгуулахаар шийдвэрлэсэн. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлох зорилго бүхий Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 6 бүлэг, 29 зүйлтэйгээр боловсруулж, УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.	
Хүрэх үр дүн: 1.Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зайн	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий				Улаанбаатар хотын 2020 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг eBarlga цахим системд оруулсан. Улаанбаатар хотын 2040	100

1	2	3	4	5	6	7
шаардлагатай төлөвлөлтэйг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.				төлөвлөгөөний концепц батлагдсан.	оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа eBatiga цахим системд холбон өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.	
Хүрэх үр дүн: 2.Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамж нэмэгдсэн байна.				Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барих төслийн хүрээнд 1863 айлын 16 орон сууц ашиглалтад орсон.	Тус чиг үүрэг нь Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжсэн.	
Хүрэх үр дүн: 6.Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлсэн байна.				Эмээлт, Налайх, Батануурын УТП-ын ХЕТ батлагдсан	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрийн хэсгийг дахин төлөвлөх, нүүлгэн шилжүүлэх зорилго бүхий барилгажилтын төсөл боловсруулах зургийн даалгаврыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн №2024/01,04 дугаартай боловсруулж батлуулсан. Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/1306 дугаар захирамжаар “Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тусгай бүсийн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал: Тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах 1,230 сая төгрөгийг нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгуулав. Төсвийн асуудал шийдэгдсэний дараа хөгжлийн ерөнхий	70

1	2	3	4	5	6	7
					төлөвлөгөөг боловсруулах нөхцөл бүрдэх бөгөөд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ-д Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр аж ахуйн нэгжийг хотоос нүүлгэн шилжүүлж, тусгай бүсэд кластер байдлаар хөгжүүлэхээр төлөвлөөд байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны өдрийн 94 дүгээр тогтоолоор “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан бөгөөд тус төлөвлөгөөнд малын гаралтай түүхий эдийн үйлдвэрүүдийг хотын төвөөс гаргахаар тусгагдсан. Тус хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын байршилд ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, хамтран ажиллахаар болов.	
8.	9.3.1. Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл	2021-2030	-	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепц батлагдсан.	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга, барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгох” ажлын хүрээнд хийгдэх геопорталын вэб, апп дизайны загвар боловсруулж санал өгсөн. Фэйсбүүк хуудасны арын зураг бэлтгэсэн. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга, барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгох” ажлын хүрээнд хийгдэх геопорталын вэб, апп дизайны загвар боловсруулж санал өгсөн. Нийслэлийн Засаг даргын А/1336 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээвэр Метроны Техник эдийн Засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын дагуу Амгалангаас Моносын уулзвар хүртэлх Метроны трассын дагуу 100м хамгаалалтын зурвасыг татаж, нөлөөлөлд өртөж буй баригдсан барилгын мэдээллийг, мөн уг төслийн хүрээнд баригдах засвар үйлчилгээний байр, депоны байршилд холбогдох саналыг тусгуулан Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл	100

1	2	3	4	5	6	7
	ажиллагааг хэрэгжүүлнэ.				хэрэгжүүлэх нэгжид 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/546 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
9.	9.3.2. Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, хот доторх төвлөрлийг багасгана.	2021-2030	-	Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ХЕТ батлагдсан.	1. Сонсголон, Амгалан, Шинэ дэд төв, Нисэх, Бичил, Ургах наран, Хайлааст олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийг 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 15 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанд өргөн барьж, батлуулсан. 2. Дамбадаржаа дэд төв /59,5 га/, Сэлбэ-2 дэд төв /733 га/, Толгойт дэд төв/123 га/-ийн хил заагийн мэдээллийг гарган Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн "Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх байршил тогтоох тухай" 107 дугаар тогтоолоор батлуулав. 3. Сэлбэ дэд төвийн Техник Эдийн Засгийн үндэслэл боловсруулах ажилд чиг үүргийн хүрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.	100
10.	9.3.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.	2021-2030	-	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барих төслийн хүрээнд 1556 айлын 13 орон сууц ашиглалтад орсон.	Тус чиг үүрэг нь Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжсэн.	-
11.	9.3.4. Олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны	2021-2030	-	-	2024 онд 34839 айлын орон сууцны барилгын Загвар зураг батлагдсан.	100

1	2	3	4	5	6	7
	хангамжийг нэмэгдүүлж, 150,000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.					
12.	9.3.5. Хотын бүсчлэлийн дүрмийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2021 2030	-	Саналын тоо	Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг Иймээс Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоосны үндсэн дээр Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг баталж улмаар Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажил хийгдэх боломжтой байх тул Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа дээрх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 01-10/177 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын баталсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар”-ын дагуу “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна. Тус төслийг 2024 оны Улсын Их Хурлын намрын чуулганд өргөн барихаар ажиллаж байна.	100
13.	9.3.6. Түүх, соёлын өвийг хадгалж, сэргээн хамгаалах, сэргээн	2021- 2030	2020 онд 25.588.000 (сая) НЗД	2 барилга	Түүх, соёлын өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо “Чойжин ламын сүм” музейн барилга, Хан-Уул дүүргийн 15-р хороо	100

1	2	3	4	5	6	7
	засварлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.				“Богд хааны ордон музей” цогцолбор барилгуудад газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийн дүгнэлтийг тус байгууллагуудад хүргүүлсэн. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал 37.2-т “Соёлын өвийг хамгааны төв байгууллага, төрийн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна.” гэж заасан байна. Цаашид уг заалттай холбоотой биелэлтийг Нийслэлийн Соёл урлагийн газраас гаргуулах саналтай байна. /Хасуулах/	
14.	9.3.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.	2021-2030	-	Эмзэлт, Налайх, Багануурын УТП-ын ХЕТ батлагдсан.	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрийн хэсгийг дахин төлөвлөх, нүүлгэн шилжүүлэх зорилго бүхий барилгажилтын төсөл, зургийн даалгаврыг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн №2024/01,04 дугаартай боловсруулж батлуулсан. Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/1306 дугаар захирамжаар “Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгийн хүрээнд тусгай бүсийн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал: Тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах 1,230 сая төгрөгийг нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгуулав. Төсвийн асуудал шийдэгдсэний дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах нөхцөл бүрдэх бөгөөд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ-д Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр аж ахуйн нэгжийг	70

1	2	3	4	5	6	7
					хотоос нүүлгэн шилжүүлж, тусгай бүсэд кластер байдлаар хөгжүүлэхээр төлөвлөөд байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор “Эмзэлт, эко аж үйлдвэрийн парк”-ын техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан бөгөөд тус төлөвлөгөөнд малын гаралтай түүхий эдийн үйлдвэрүүдийг хотын төвөөс гаргахаар тусгагдсан. Тус хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Эмзэлт эко аж үйлдвэрийн парк”-ын байршилд ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, хамтран ажиллахаар болов.	
15.	9.3.8. Газар доорх орон зайг оновчтой ашиглаж зам, тээвэр, инженерийн шугам сүлжээнд ашиглана.	2021-2030	-	Судалгааны ажил хийгдсэн.	- Газар доорх худалдаа, нийтийн үйлчилгээний төв гудамжны судалгааны хүрээнд одоо байгаа инженерийн шугам сүлжээний тодруулга, төлөвлөлтийн талаар шийдэл хүргүүлсэн. - Нисэхийн тойргоос Үндэсний цэцэрлэгт хүрээлэн хүртэл одоо байгаа дулааны шугам сүлжээний 2ф800/500/400/350/300/250/200/150мм-ийн голчтой 0.177 км дулааны шугам төлөвлөж буй тусгай замын нийтийн тээврийн трасст (BRT) өртсөн дулааны шугам сүлжээний суваг, сувгийн хучилтыг хүчитгэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулах талаар санал хүргүүлсэн.	100
16.	9.3.10. Олон Улс, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөгч метрополитан хот болж хөгжинө.	2021-2030	-	УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо-1	Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн дагуул хотоор Багахангай хот, Агросити хот, Шарга морьт дагуул хотуудыг тус тус байгуулсан. Тус тогтоолоор дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоож Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх үүрэг даалгавар өгөгдсөний дагуу Агросити дагуул хотын (20853 га), Шарга морьт дагуул хотын (11137.3 га) эдэлбэр газрын хэмжээг тодорхойлон шийдвэрийн төслийг боловсруулж 2025 онд Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. - Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 2,332.72 сая, Шарга морьт	100

1	2	3	4	5	6	7
					дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 1065.8 сая төгрөгийн төсвийг нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулах тухай санал боловсруулан НЗДТГ-т 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/445 дугаартай албан бичгээр хүргүүлж, төсөвт тусгагдсан.	
17.	9.3.13. Хотын хэвтээ, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, дагуул, хаяа хотын авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021-2030	-	-	- Авто зам, замын байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар олгох, загвар зураг батлуулах 44 хүсэлтийг хүлээн авч, хот байгуулалтын судалгаа хийж, 29 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, 14 байршилд эх загвар зураг батлуулж мэдээллийн санд тусгасан. 29 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулснаас Авто зам замын байгууламж 25 байршилд 42,3 км, 1 байршил авто машины ил зогсоол, дугуйн зам 8 байршилд 31,9 км замын архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан.	100
18.	9.3.31. Богдхан уулыг тойрсон зорчигч тээврийн сүлжээг байгуулна.	2021-2030	-	ТЭЗҮ боловсруулсан.	- Шинээр барих авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгаврын хүрээнд гүйцэтгэж ирүүлсэн авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөлд санал зөвлөмж өгч шаардлагатай зураг төслийг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Авто зам замын байгууламж 5 байршилд 10,9 км, Дугуйн зам 9 байршилд 13,1 км замын загвар зургийг батлуулсан.	-
19.	9.3.32. Ачаа тээврийн Богдхан төмөр зам барьж байгуулна.	2021-2030	-	-	Нийслэлийн 2021,2022,2023 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн. Зам, тээврийн яам хариуцан ажиллаж байна. Хөгжлийн алтан тойрог концепцийн хүрээнд тусгагдсан. 2024 онд тус ажлын хүрээнд ажил хийгдээгүй байна.	-

1	2	3	4	5	6	7
					Зам, тээврийн яам хариуцан ажиллаж байна. Хөгжлийн алтан тойрог концепцын хүрээнд тусгагдсан. 2024 онд тус ажлын хүрээнд ажил хийгдээгүй байна.	
20.	9.3.34. Бүс нутгийг Улаанбаатар хоттой холбосон тусгай замын өндөр хурдтай тээврийг нэвтрүүлнэ.	2021 2030	-	-	- Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд Олон Улсын стандартыг бүрэн хангасан Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барьж байгуулах гүйцэтгэгч оролцогчийг сонгон шалгаруулах ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэгт ажиллаж холбогдох саналыг даалгаварт тусгуулсан. "Метро"-ний нэгдүгээр чиглэл болох Улиастайн гүүрнээс, (Моносын уулзвар)-Сонсголонгийн зам хүртэлх шугамын зөвлөх үйлчилгээний ажилд холбогдох саналыг хүргүүлсэн. Метро барих төслийн зөвлөх үйлчилгээний ажлын орон зайн төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн хүрээнд санал зөвлөмж өгөх ажлын хэсэгт ажиллаж байна.	100
					- Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр Улаанбаатар хотын хөндлөн чиглэлд Нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобус BRT төслийг гүйцэтгэж буй "Far east Mobility"-ийн ирүүлсэн тайлантай танилцаж 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/85 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид санал хүргүүлсэн. Төслийн нэгжээс зохион байгуулсан 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн хуралд оролцож санал, зөвлөмж өгсөн. Тусгай замын тээвэр BRT Нисэх-Үндэсний цэцэрлэгт хүрээлэн хүртэлх хоёрдугаар чиглэлийн авто замтай хөндлөн огтлолцож байгаа болон авто зам дагуу таарч байна.	
21.	9.3.39. Хаягдал лаг, тунадасыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн	2021- 2030	-	Ажлын зургийн даалгавар батлуулсан.	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх Төв цэвэрлэх байгууламжийн лаг хатаах, шатаах	-

1	2	3	4	5	6	7
	болгох, эргүүлэн ашиглах гол шугам сүлжээг төслийг хэрэгжүүлнэ.				байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт санал өгсөн. Шинээр баригдаж байгаа Төв цэвэрлэх байгууламжийн лаг хатаах, шатаах байгууламжийг барих ажлын санхүүжилтийг Мянганы сорил сангийн буцалтгүй тусламжаар хийлгэхээр санал оруулсан. (УБЗАА хариуцан ажиллаж байна.)	
22.	9.3.40. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун доод эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, дамжуулах шугам барьж ашиглалтад оруулна.	2021-2030	-	Ажлын зураг төсөл батлагдсан.	Монголын Мянганы сорилтын сан /MCC/ нь Монгол улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан хоёр дахь компакт гэрээний хүрээнд “Улаанбаатар хотын ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл” гэрээний дагуу 2026 оны 03 дугаар сарын 31-ний дотор хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд ус дахин цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 82,4%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийн хэмжээнд ажлын зургийн материалыг нууцад бүртгэн байгууллагын нууцын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. Ус цэвэршүүлэх үйлдвэрийн гаргалгааны сувгийн өөрчлөлтийн ажлын зураг төслийг хянаж зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Доод эх үүсвэрээс ус цэвэршүүлэх үйлдвэр хүртэлх цэвэр усны шугамын барилга угсралтын ажил хийгдэж байна.	100
23.	9.3.42. Инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн хангасан, үерийн хот эрсдэлгүй болно.	2021-2030	-	Инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгавар 31 байршил, шугам сүлжээний 33 ширхэг ажлын зураг хүлээн авч зөвшилцсөн.	Инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын хүрээнд 2024 онд 62 ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн сан eBaiIga цахим системд оруулж, хамгаалалтын зурвас тогтоосон.	100
24.	9.3.44. Инженерийн дэд бүтцийн шинэ	2021-2030	-	-	Эрчим хүчний яамнаас Улаанбаатар хотод том чадлын батареи хуримтлуур бүхий дэд станц байрлуулах	70

1	2	3	4	5	6	7
	шийдэл, технологийг нутагшуулна.				боломжтой байршлуудыг ирүүлсэн бөгөөд 220/110/35кВ-ын Багануур дэд станцад 50/200мвт/ц чадал бүхий хуримтлуурын станц байгуулахаар ажлын хэсэг байгуулагдсан. Эрчим хүчний яамнаас тус дэд станцын техникийн нөхцөл олгогдсон, бөгөөд газар олголтыг шийдвэрлүүлэн архитектур төлөвлөлтийн даалгавар олгогдож, эх загвар зургийг баталгаажуулж нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т хүргүүлсэн. Төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Энвижин энержи” ХХК шалгарч 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, барилга угсралтын ажил хийгдэж байна.	
25.	9.3.46. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.	2021-2030	-	1252 байршил	Шинэ Зуунмод дагуул хотын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 128.5 км авто зам, 250 МВт цахилгаан, 465 МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны цахилгаан станц болон хоногт 20 мянган шоо метр бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих ажлыг 2025 оноос эхлүүлнэ. Шинэ Зуун мод хотын ерөнхий төлөвлөгөө батлагдсанаас хойш 160-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	100
26.	9.3.47. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн бие инженерийн хангамжид холбон сэргээгдэх эрчим хүчийг ашиглана.	2021-2030	35 тэрбум Төг /2022 оны улс нийслэлийн төсөвт тусгагдсан/	-	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 6 байршилд төсөл хэрэгжүүлэгчийн саналаар шинэчлэн баталсан барилгажилтын төслийн инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцсөн. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотод байгаа нийт 297 хатуу түлшний зуухын 45 байршлыг хийн түлш рүү шилжүүлэхийг ажлын хэсэгт холбогдох санал хүргүүлсэн. Эрчим хүчний Сайдны 2024 оны А/66 дугаар тушаалаар баталсан нийслэлийн гэр хороололд хуримтлуур бүхий нарны бага чадлын эх үүсвэрийг тархмал хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг судлах ажлын хэсэгт ажиллаж дүгнэлтээр Багануур дүүрэгт их багтаамжийн цэнэг	100

1	2	3	4	5	6	7
					хуримтлуулах станц байгуулах шийдэл боловсруулан эхний ээлжийн 50МВт-ын эх үүсвэр барих ажил 80 хувийг гүйцэтгэлтэй хийгдэж байна. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны “Эрчим хүчний сэргэлтийн төсөл”-ийн жагсаалтад “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэр” төсөл арга хэмжээний хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн газарт 2 дулааны эх үүсвэр төлөвлөгдөж байгаа бөгөөд эхний ээлжид цэцэрлэгт хүрээлэнгийн баруун урд талд 112МВт/ц хүчин чадал бүхий эх үүсвэрийг барихаар 2024 оны улсын төсөвт 20 тэрбум төгрөгийг суулгаж, станцыг барьж байгуулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 2 үе шат бүхий тендерийг зарлаад байна. Тус эх үүсвэрт 6,1 га газар шаардлагатай бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэгдэхээр намуудын бүлгийн хуралд танилцуулснаар санал дэмжигдээгүй байна. Мөн Их засаг хийн дулааны станц, Нисэх орчимд хийн дулааны станц барихаар төлөвлөгдсөн ба газар олголтын асуудлыг Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	
Санал дүгнэлт: Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг яаралтай батлуулж тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.						
27.	9.4.2. Хотын нэгдсэн стандартыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх тогтолцоог бий болгоно.	2021-2030	-	22 багц боловсруулсан	Хотын стандартыг мөрдүүлэх, тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төсөл болон арга зүйн зааврыг боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулахаар бэлтгэл арга хэмжээг хангаж байна. Иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн 15 бүлгийн 52 хотын стандартыг боловсруулж 2022 оноос эхлэн Нийслэлийн	90

1		2	3	4	5	6	7
						иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар үе шаттайгаар батлуулан хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Дараагийн ээлжид батлуулахаар төлөвлөж буй 7 бүлгийн 16 хотын стандартын төслийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, норм дүрэм, стандартад нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1044 дүгээр "Хотын стандартын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, иргэд, олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, хянан тохиолдуулах эрх бүхий байгууллагаар батлуулах асуудлыг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-г танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
Дагуул хот							
Зорилт 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, бий үйлдвэрлэлийг болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.		2021-2030	-	12 дагуул хот, тосгодын ХЕТ батлагдсан.	- Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд нийслэлийн нийт нутаг дэвсгэрийг хамруулан төмөр замын дэд бүтцийг дагуулан эдийн засгийн ач холбогдолтой ачаа тээврийн томоохон терминал бүхий логикийн төвийг Шинэ Зуун-Мод хуурай боомтыг түшиглэн байгуулахаар тусгасан. - Шинэ Зуунмод хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс нь 2507.1 га талбайд төлөвлөгдсөн бөгөөд 52 улсын 375 цэгт нислэг үйлдэх боломжтой болсон. 2023 онд нийт 15000 орчим нислэг үйлдэж, 1.7 сая зорчигчдод үйлчилсэн. "Шинэ Зуунмод" инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажилд Барилга хот байгуулалтын сайдын багцад нийт 32,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажил суулгаснаас 2022-2024 онд гэрээлсэн дүнгээр 31,8 тэрбум төгрөгийн 3-н дэд бүтцийн ажлын санхүүжилт бүрэн хийгдсэн. Мөн Эрчим хүчний сайдын багцад нийт 127,829.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажил суулгаснаас 2022-2024 онд гэрээлсэн дүнгээр 127,219.4 тэрбум төгрөгийн 7-н дэд бүтцийн ажлаас 52,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.		
Хүрэх үр дүн: 1.Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.				-	70		
					100		

1	2	3	4	5	6	7
Хүрэх үр дүн: 2.Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.				Тэрэлж, Гачуурт тосгоны ХЕТ батлагдсан.	- Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд нийслэлийн нийт нутаг дэвсгэрийг хамруулан төмөр замын дэд бүтцийг дагуулан эдийн засгийн ач холбогдолтой ачаа тээврийн томоохон терминал бүхий логистикийн төвийг Шинэ Зуун-Мод хуурай боомтыг түшиглэн байгуулахаар тусгасан. - Шинэ Зуунмод хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс нь 2507.1 га талбайд төлөвлөгдсөн бөгөөд 52 улсын 375 цэгт нислэг үйлдэх боломжтой болсон. 2023 онд нийт 15000 орчим нислэг үйлдэж, 1.7 сая зорчигчдод үйлчилсэн. Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Шинэ Зуунмод дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд экспортын баримжаатай импортыг орлох хүнсний, химийн, технологийн, холимог үйлдвэрүүд байхаар 570 га талбайд үйлдвэрийн бүсийг төлөвлөсөн. Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Нийслэлийн дагуул хотоор Багахангай хот, Агросити хот, Шарга морьт дагуул хотуудыг тус тус байгуулсан. НЗДТГ-т 2024 оны 01/445 дугаартай албан бичгээр Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 2,332.72 сая, Шаргаморьт дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 1065.8 сая төгрөгийн төсвийг нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулах тухай санал боловсруулан хүргүүлж, төсөвт тусгуулсан.	100
Хүрэх үр дүн: 3.Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төв нээгдэнэ.				12 дагуул хот, тосгодын ХЕТ батлагдсан.	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га талбайд хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр тус бүр эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг	70
Хүрэх үр дүн: 4.Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлнэ.				-	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га талбайд хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр тус бүр эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг	100

1	2	3	4	5	6	7
					даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/1306 дугаар захирамжаар “Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг хүлээлцэж, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК”-ийн албан хаагчидтай 2024.11.09-ний өдөр уулзалт зохион байгуулж, 2024.11.22-ны өдөр паркийн байршилд ажиллав. 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Багахангай дүүргийн үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ-ын аж ахуй агуулахын барилгын төлөвлөлт, орц гарц болон төлөвлөлтийн авто замын трассыг Багахангай дүүргийн үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан санал өгсөн.	
1.	9.5.1. Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын	2021-2030	-	-	1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгуулагдсан дагуул хотуудын эдэлбэр газрын хил хязгаарыг тодорхойлж, Нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулах саналаа боловсруулан НЗДТГ-ын 2024 оны 01/445 дугаартай албан бичгээр хүргүүлж, нийслэлийн төсөвт тусгуулсан. Үүнд: - Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 2,332.72 сая төгрөг, - Шаргаморьт дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 1065.8 сая төгрөг, - “Агросити” ЭЗТБ-ийн ХЕТ боловсруулахад шаардагдах 1831.4 сая төгрөг, - “Налуу-Ухаа” ЭЗТБ-ийн ХЕТ боловсруулахад шаардагдах 1230.1 сая төгрөг, Дагуул хотуудын хөгжлийн төлөвлөгөөнд худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй,	100

1	2	3	4	5	6	7
	төвлөрлийг сааруулна.				хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын бүсүүдийг тусгахаар төлөвлөн ажиллаж байна. 2. Улсын Их Хурлын 2024 оны "Хот байгуулах тухай" 72 дугаар тогтоолоор байгуулагдсан "Агро сити" дагуул хотын нутаг дэвсгэр дээр Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан "Агросити" эдийн засгийн тусга бүс нь хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжих бөгөөд, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах төсвийг нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулах тухай санал боловсруулан НЗДТГ-т 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/445 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	
2.	9.5.2. "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021-2030	-	-	"Шинэ Зуунмод" инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажилд Барилга хот байгуулалтын сайдын багцад нийт 32,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажил суулгаснаас 2022-2024 онд гэрээлсэн дүнгээр 31,8 тэрбум төгрөгийн 3-н дэд бүтцийн ажлын санхүүжилт бүрэн хийгдсэн. Мөн Эрчим хүчний сайдын багцад нийт 127,829.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажил суулгаснаас 2022-2024 онд гэрээлсэн дүнгээр 127,219.4 тэрбум төгрөгийн 7-н дэд бүтцийн ажлаас 52,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.	100
3.	9.5.3 Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах "Шинэ Зуунмод" шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.	2021-2030	-	-	Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Шинэ Зуунмод хотын Захирагчийг томилж, 2024 оны 67 дугаар тогтоолоор Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоог баталсан. Шинэ Зуун мод хотын ерөнхий төлөвлөгөө батлагдсанаас хойш 160-аад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.	100
4.	9.5.5. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа	2021-2030	-	Эмээлт, Налайх, Багануурын УТП-	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн газар ашиглалтын өнөөгийн байдлын судалгаа, Солонгосын Сөүл хотын нүүлгэн шилжүүлэлт	100

1	2	3	4	5	6	7
	үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.			ын ХЕТ батлагдсан	хийж амжилттай хэрэгжүүлсэн туршлагаас судлан судалгаанд нэгтгэн боловсруулав. Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5650 га талбайд тээвэр логистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1306 дугаар захирамжаар “Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг тусгай бүсийн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал: Тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардагдах 1,230 сая төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгуулав. Төсвийн асуудал шийдэгдсэний дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах нөхцөл бүрдэх бөгөөд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ-д Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр аж ахуйн нэгжийг хотоос нүүлгэн шилжүүлж, тусгай бүсэд кластер байдлаар хөгжүүлэхээр төлөвлөсөн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 94 дүгээр тогтоолоор “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсан бөгөөд тус төлөвлөгөөнд малын гаралтай түүхий эдийн үйлдвэрүүдийг хотын төвөөс гаргахаар тусгагдсан. Тус хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын байршилд ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, хамтран ажиллахаар болов.	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 63 их, дээд сургуулиас эхний ээлжид Шинэ Зуунмод хотын оюутны хотхон судалгаа шинжилгээний хүрээлэн бүхий шинэ суурьшилд соёл урлаг, инновац техник технологийн өндөр
5.	9.5.6. Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь	2021-2030	-	-		90

1	2	3	4	5	6	7
	төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна.				ач холбогдол бүхий сургуулиудыг шат дараатай суурьшуулах тухай судалгааны дата мэдээллийг нэгтгэв. Их дээд сургуулийг салбар чиглэлээр төрөлжүүлэн шилжүүлэх боломж, төвлөрөл түгжрэлийн таталцал нөлөөллийг цогц байдлаар тооцоолох судалгаа боловсруулахад 120,000,000 төсөв шаардлагатай ба Нийслэлийн хөгжлийн 2024 оны төсвийн тодотголд Нийслэлийн хөгжлийн саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын тусгуулахаар саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01/486 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. (тусгагдаагүй)	
6.	9.5.16. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	2021 2030	-		БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын техник туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол Улсад бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийн зөвлөх багтай 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж уулзалтаар төрийн байгууллага болон их дээд сургуулийг дагуул хотууд руу нүүлгэн шилжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлж, ирэх 3 жилд хамтран ажиллахаар болов.	
Санал дүгнэлт:					Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хариуцна.	-
- Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, дагуул хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, барилгажилтын төслүүдийг яаралтай боловсруулж батлуулах. - Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэх ажлыг засгийн хэмжээнд шийдвэр гарган холбогдох яам, нийслэлийн удирдлагууд хамтран ажиллах						

Нийт 45 арга хэмжээнээс хэрэгжилтийн дундаж 95.2 хувьтай байна.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.ДАШЦЭЦЭГ

 Л.ЭНХТУУЛ

НЭГТГЭСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 Л.АДЪЯАСҮРЭН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН